



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 онь 04 сарын 22 өдөр

Дугаар А/212

Хэрлэн сум

**Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах
үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөлийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66 дугаар зүйлийн 66.3, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, салбар дундын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд уялдуулан зохицуулах, хуулийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах үүрэг бүхий орон тооны бус салбар зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг дараах байдлаар шинэчлэн баталсугай.

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, судалчилгаа, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Эрүүл мэндийн газрын дарга

Нийгмийн даатгалын газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны тэргүүн

Монголын Хараагүй иргэдийн холбооны Хэнтий аймгийн салбар зөвлөлийн дарга

Аймгийн Тэргэнцэртэй иргэдийн холбооны тэргүүн

Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны тэргүүн

2.


Нарийн бичгийн
дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн дарга

2.Салбар зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэний боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал болон тэдний орчин нөхцөлийг сайжруулах талаар үр дүнтэй ажиллахыг орон тооны бус салбар зөвлөлийн гишүүдэд, хяналт тавьж арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д тус тус даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/642 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ